



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/668

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2022/408 дугаар гэрээт Есөнбулаг сумын Индэрт багийн гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Г.Золзаяа	(Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
	Н.Золжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)
	Р.Нямжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны барилга, хөрөнгө оруулалт, сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн)

0201901419

2.

Д.Байгальмаа ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ашиглалтын инженер) (ашиглагч)  
М.Буянхишиг ("ДНТ" ХХК-ийн ерөнхий инженер) (зохиогч)  
Б.Нямбаатар ("Вентана констракшн" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)


Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Инженерийн барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар (Ж.Батцэцэг), "Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Э.Энхболд)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



